



МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

Цогц арга хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 4.5.10.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээг хавсралт ёсоор баталсугай.
2. “Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг Гадаад харилцааны яамны жил бүрийн төсөвт суулган батлуулж, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаярт даалгасугай.
3. “Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээний хэрэгжилтийг жилд 2 удаа тайлагнаж байхыг Гадаад сурталчилгаа, соёлын харилцааны газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Сэрээжавт даалгасугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ